



“McKinney-Vento” Хөтөлбөрт Сурагч Тодорхойлох Маягт

20__ - 20__ Хичээлийн Жил

I ХЭСЭГ: ШАЛГУУР [ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ БӨГЛӨНӨ]

Арлингтоны Улсын Сургуулийн “McKinney-Vento” Хөтөлбөр нь “McKinney-Vento Homeless Education Assistance Act” хуулийн хүрээнд орон гэргүй хүүхэд залууст төрөөс үзүүлэх үнэ төлбөргүй зохист боловсролын үйлчилгээнд бүрэн хамрагдах боломжийг олгох холбооны санхүүжилттэй хөтөлбөр юм. Энэ маягт нь АУС-д сурч буй, улмаар орон гэргүй болох асуудал тулгарсан сурагчдыг илрүүлж тэдэнд туслах явдал юм. Энэ маягтад авагдаж буй мэдээллүүд **нууц** байна. “McKinney-Vento” Үйлчилгээний тухайн дэлгэрэнгүйг АУС-н <https://www.apsva.us/departments/dei-student-support/mckinney-vento/> вэб хуудаснаас үзэх эсвэл (703) 228-6046 дугаарт залгаж тодруулна уу.

“McKinney-Vento” дэмжлэгт тэнцэх эсэхийг тодруулахын тулд дараах асуултад хариулна уу:

- Таны одоогийн хаяг түр байр бөгөөд, хэрэв тийм бол энэ нь орон гэргүй ☐ Тийм ☐ Үгүй болсон юм уу эсвэл санхүүгийн бэрхшээлээс үүдсэн эсэх?
- Сурагч өөрийн эцэг эх, асран хамгаалагчаас өөр хүнтэй амьдарч буй ☐ Тийм ☐ Үгүй эсэх?

Дээрх 2 асуултад **ҮГҮЙ** гэж хариулсан бол энд зогсоно уу. Энэ маягтыг **буцаан ирүүлэх шаардлагагүй**.

Хэрэв та эдгээр асуултуудын **аль нэгд ТИЙМ** гэж хариулсан бол орон гэргүй хүмүүст үзүүлэх үйлчилгээнд хамрагдах эрхтэй байж болно. Үүний тулд **II ХЭСГИЙГ** бөглөж энэ маягтыг сургуульдаа илгээнэ үү.

II ХЭСЭГ: СУРАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Эцэг эх, Асран хамгаалагчийн нэр(с)

Хаяг _____
ГУДАМЖ _____ ХААЛГАНЫ # _____ ХОТ _____ МУЖ _____ ЗИП КОД _____
 Гэрийн утас _____ Ажил _____ Гар утас _____
 Имэйл _____ Хэл (Англи хэлээс өөр бол) _____

Нэрс (өрхийн бүх хүүхдийг бичнэ үү)	Төрсөн огноо	Анги	Сургууль	Сурагчийн ID

Одоогийн амьдарч буй нөхцөл?

- ☐ Санхүүгийн гачигдал, гэргүй болсон гэх мэт шалтгаанаар өөр айлд амьдарч, байнга нүүж байгаа.
- ☐ Өөр сонголтгүйн улмаас дэн буудал, зочид буудалд – Буудлын нэр _____
- ☐ Орон гэргүй хүмүүсийн түр байр, хүчирхийллээс хамгаалах байр-Байрны нэр _____
- ☐ Шилжилтийн байр - Байрны нэр _____
- ☐ Машин, парк, задгай талбай гэх мэт орон сууцны зориулалтгүй газар _____

Манай хүүхдийг Арлингтоны Улсын сургууль (АУС)-д бүртгэх нь миний өгсөн мэдэгдэлд суурилсан бөгөөд хэрэв би ташаа мэдээлэл өгсөн бол би хүүхдийн сургалтын төлбөрийг бүрэн буцаан төлөхийг ойлгож байна. **Виржиниа мужийн §22.1-264.1 хуулийн** дагуу сургалтын төлбөрөөс зайлсхийх үүднээс хүүхдийн орон байрны нөхцөлийг худал мэдээлэх нь 4-р зэргийн иргэний зөрчилд тооцогддог. Мөн миний болон хүүхдийн орон байрны нөхцөл өөрчлөгдсөн нөхцөлд өөрчлөлт орсон өдрөөс гурав (3) хоногийн дотор сургуулийн захирал юм уу хамаарах албан тушаалтанд энэ тухай мэдэгдэх болно.

☐ Би “Rights of Homeless Students” (Орон Гэргүй Сурагчдын Эрх)-ийн хуулбар хүлээж авсан.

Эцэг эх/ Асран хамгаалагчийн гарын үсэг (заавал зурна)

Огноо

БҮРТГЭГЧ НАРТ: Маягтыг сургуулийн нийгмийн ажилтанд эсвэл elizabeth.ryan@apsva.us хаягт илгээнэ

Арлингтон Улсын Сургууль – Сурагчдад Үйлчлэх Алба McKinney-Vento Хөтөлбөр

ОРОН ГЭРГҮЙ СУРАГЧДЫН ЭРХ

“McKinney -Vento Homeless Assistance Act” хуулийн дагуу Арлингтон Улсын сургууль (АУС) нь бүх сурагчдын нэр төрийг дээдэлсэн, хүндэтгэлтэй сургалтын орчныг бүрдүүлж ажиллана. АУС-ийн орон гэргүй сурагч бүр орон сууцны асуудалгүй сурагчидтай нэгэн адил төрөөс үзүүлэх үнэ төлбөргүй, зохист боловсрол эзэмших боломжийг тэгш хүртэх ёстой. Энэхүү орон гэргүй хүүхдүүд, залуус, эцэг эх юм уу асран хамгаалагчтайгаа хамт амьдардаггүй залуусын боловсролын эрхтэй хамаарах үүрэг нь АУС-ээс үзүүлж буй эсвэл ашиглах боломжтой бүх үйлчилгээ, хөтөлбөр, үйл ажиллагаанд хамаарна.

Дараах нөхцөлд буй сурагч “McKinney-Vento”-д хамрагдана:

- Орон гэрээ алдсан эсвэл санхүүгийн хүндрэлийн улмаас бусад хүмүүстэй түр хугацаагаар амьдарч буй
- Тохиромжтой өөр байр байхгүйн улмаас дэн буудал эсвэл зочид буудалд түр хугацаагаар амьдарч буй
- Гамшгийн үеийн хоргодох байр эсвэл гэр бүлүүдийг хамгаалах байранд амьдарч буй
- Шилжилтийн орон сууцанд амьдарч буй
- Машин, зуслангийн газар эсвэл задгай талбай, паркт хоргодох газаргүй амьдарч буй
- Асран хамгаалагчгүй орон гэргүй залуучууд гэх мэт нөхцөлүүд.

Орон гэргүй сурагчид дараах эрхтэй:

- **Сургуульд шууд бүртгүүлж орох.** *Сургууль нь сурагчийг эрүүл мэнд, дархлаажуулалт, сургуулийн бүртгэл, асран хамгаалагчийн нотлох баримт, оршин суугаа газрын хаяггүй байсан ч нэн даруй бүртгэж авах ёстой.*
- **Бүртгэж авах сургуулиуд:**
 - *байнгын орон гэртэй байх үеийн сурч байсан сургууль (үндсэн сургууль)
 - *хамгийн сүүлд сурч байсан сургууль (үндсэн сургууль)
 - *орон гэргүй хүүхэд, залуучууд тухайн үед амьдарч буй бүсэд хамаарах орон гэртэй хүүхдүүдийн хамран суралцах аль нэг сургуульд суралцах боломжтой.
- Сонгосон сургуульдаа орон гэргүй байх хугацаандаа, эсвэл сурагч байнгын орон гэртэй болсон бол тухайн хичээлийн жил дуустал **үргэлжлүүлэн суралцах.**
- Сургуулийн өмнөх боловсролын зарим хөтөлбөрүүдэд **давуу эрхээр суралцах.** Эцэг эх, асран хамгаалагчдыг эдгээр хөтөлбөрт хандахыг зөвлөж байна.
- Хэрхэн хураамжаас чөлөөлөгдөх, дүрэмт хувцас үнэ төлбөргүй авах, хямд үнээр эсвэл үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээний талаар **мэдээлэл авах.**
- **Автобусны үйлчилгээ** Үндсэн сургуульдаа суралцаж буй орон гэргүй сурагч орон гэргүй байх хугацаанд, хэрэв байнгын орон гэртэй болсон тохиолдолд хичээлийн жил дуустал тухайн сургуульдаа явах, буцах автобусаар зорчих эрхтэй. АУС-ийн ажилтнууд гэр оронгүй эцэг эх/асран хамгаалагч, залуу сурагчдад сургуульд ирэх/ буцах болон сургуультай холбоотой үйл ажиллагаанд ашиглах автобусны талаар мэдээлнэ.

Хэрэв та орон гэргүй хүүхэд, залуучуудын сургуулийн бүртгэл, сургуулийн автобус юм уу эрх тэгш хандахтай холбоотой асуудлуудаар сургуулийн удирдлагуудтай санал нийлэхгүй байгаа бол гомдол гаргаж болно. Маргаан шийдвэрлэх үйл явцтай холбоотой мэдээллийг Сурагчдад Үйлчлэх Албаны 703-228-6046 утсаар холбогдож авах боломжтой.